Ярилцлага өгөгчийн нэр	Жамц	Дугаар	L359
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Эрдэнэдалай сум
Төрсөн газар	Эрдэнэдалай сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Үнэстэйн хийд	Сүм хийдийн дугаар	ДУЭД 007
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 24	Ярилцлага авсан хүн	Жужа

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Үнэстэйн хийд

Жужа: Үнэстэйн хийд хичнээн дугантай байсан бэ?

Жамц: Гурван дугантай байсан/ Жамц гуай чих нь сонсгол нэлээд муудсан учир түүний ач хүү бололтой нэгэн 24-25 орчим насны залуу хэлсэн ярьсын нь дамжуулж байв/

Жужа: Үнэстэйн хийдийн тухай та мэддэг, үзсэн сонссон зүйлээ ярина уу?

Жамц: Дал гарүй ламтай байсан юм гэнэ лээ.

Жужа: Хэдэн онд байгуулагдсан, ямар ямар хурал хурдаг байсан тухай та ярина уу?

Жамц: Хэдэн оныг би мэдэхгүй. Гучин долоон онд цэрэгт явсан юм, би. Цэрэгт явахаасаа өмнө бага байхдаа л хийд рүү очдог байсан.

Жужа: Энд цам гарч, майдар эргэдэг байсан юм болов уу?

Жамц: Майдар эргэж байсан. Өөр юм байгаагүй.

Жужа: Майдар хээээ эргэдэг байсан юм бол?

Жамц: Зүн эргэдэг байсан.

Энхбаяр: Хайлан хурдаг байсан уу?

Жамц: Хайлан хурдаг байсан юм гэнэ лээ.

Энхбаяр: За энэ хийдийн тэргүүн дээд лам нар нь цогрж гэдэг юм уу, хамба гэдэг юм уу тэр хүн нь ямар хүн байсан бэ?

Жамц: Манай хошууны Сандуйдорж , Цамба гэвш гэж хоср том лам байсан, ах дүү хоёр. Тэр хоёр энэ хийдэд сууж байсан юм.

Энхбаяр: Лүйжин энэ тэр тавьдаг зоч лам байсан уу?

Жамц: Үгүй тийм юм байхгүй байсан санагдана.

Жужа: Энэ хийдээс төрсөн хүтагт хувилгаад том лам нар бий юу?

Жамц: За яг энэ хийдэд бол байхгүй. Харин тэр Онгийн хийдийн хамба чинь манай нутгийн хүн. Таван настай нутгаасаа гарч Онгийн хийдэд шавилж сууғаад хамбыг нь хүртэл явсан. Харин Үнэстэйн хийдэд миний төрсөн ах нэг сайн лам байж байгаад гучин долоон онд баригдаж яваад эргэж ирээгүй.

Жужа: Хичнээн суварга байв, ганжуур хурдаг байсан уу?

Жамц: Суварга байгаагүй санагдаж байна. Ганжуур бол хурдаг байсан.

Жужа: Жастай байсан уу?

Жамц: Хийдийн малыг бог голдуу, тэгээд үхэр малыг хариулдаг жас, тэр хийдийнхээ баруунтаа гувээний наахна бууцанд байдаг байсан.

Жужа: Үнэстэйн хийдийг хэдэн онд хааж хэдэн онд нураасан юм бол?

Жамц: Намайг жил цэрэгт явах жил хаагаад лам нарыг нь бариад явчихсан юм гэнэ лээ. Дөрвөн жил гаран цэргийн алба хаагаад ирэхэд гурван дуган хагас дутуу нураагдсан байсан. Тэгээд үвүү цувуу хүмүүс нурааж модыг нь авсаар байгаад 2-3 жилийн дотор юу ч үгүй болсон. Харин бүр хожуу саяхан болтол түүрин дээр нь шавар бурхан судар номын тасархай, ширмэн тогооны хагархай байж л байдаг байсан. Одоо юу ч үгүй болсон байна лээ.